



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/577


Эрдэнэт

Цагдаагийн газрын дугуйт эргүүлийн унадаг дугуй
худалдан авах хөрөнгө гаргах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1. 6/в/, 29.2, Цагдаагийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.5 дахь заалтууд, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгө, түүний зориулалтын нийтлэг журмын 2.13-т заасныг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Эрдэнэт хотод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дугуйт эргүүл ажиллуулах зорилгоор Цагдаагийн газарт дугуйт эргүүлийн унадаг дугуй худалдан авах хөрөнгийг хавсралтаар баталсугай.


2.Унадаг дугуй түүний дагалдах хэрэгсэл худалдан авахад шаардагдах 8.000.000 /найман сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДУГУЙТ ЭРГҮҮЛИЙН УНАДАГ
ДУГУЙ ХУДАЛДАН АВАХ ХӨРӨНГӨ

№	Нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Унадаг дугуй	2018-АТХ-830	5	1.380.000	6.900.000
2	Түшүүрэг		5	45.000	225.000
3	Хамгаалалтын малгай		5	75.000	375.000
4	Урд хойд гэрэл		5	55.000	275.000
5	Шаврын хаалт		5	45.000	225.000
6	Усны сав тогтоогч		5	-	-
	Нийт дүн		30	1.600.000	8.000.000